

МУБИС-ийн ректорын 2025 оны 01 дүгээр сарын 23-ний
өдрийн 169 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР /2025-2027/

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Үндэслэл, хэрэгцээ

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа" 2050, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө" /2021-2030/, Боловсролын ерөнхий хууль /2023/, Дээд боловсролын хууль /2023/, Багшийн хөгжлийг дэмжих хууль /2018/, МУБИС-ийн стратеги төлөвлөгөө /2025-2030/, МУБИС-ийн "Багшийн ажиллах журам" /2023/, МУБИС-ийн ёс зүйн дүрэм /2020/, МУБИС-ийн "Сургалтын журам" /2023/ зэрэг бодлогын болон эрх зүйн баримт бичгүүдийг МУБИС-ийн Багшийн хөгжлийн хөтөлбөрийн үзэл баримтлал болгон боловсруулав. Эдгээр баримт бичигт их, дээд сургуулийн төгсөгчдийн чанарыг дэлхийн жишигт хүргэх, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд суралцахуйн үр дүнг шатлан олгох бүтэц, агуулга, арга зүй, үнэлгээний нэгдсэн тогтолцоогоор хөгжүүлэх, бодлого, эрх зүйн орчныг тодорхой болгох, хүний нөөцийг чадавхжуулж, тэдний мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, үр өгөөжтэй туршлагыг түгээн дэлгэрүүлэх замаар дээд боловсролын чанар, үр дүнг дээшлүүлэх зэрэг зорилтыг тусгасан байна.

Олон улсын дээд боловсролын хөгжлийн чиг хандлага, Монгол Улсын дээд боловсролын бодлого, хууль эрх зүйн орчны шинэчлэл, МУБИС-ийн алсын хараа, эрхэм зорилготой уялдуулан стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Багшийн хөгжлийн хөтөлбөрийг өмнөх хөтөлбөрийн үр дүнд үндэслэн, шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна.

1.2. Хамрах хүрээ

МУБИС-ийн дадлагажигч багш, багш, ахлах багш, дэд профессор, профессорын албан тушаалын зэрэглэлд ажиллаж буй багш нар тус хөтөлбөрт хамрагдах бөгөөд бүрэлдэхүүний болон салбар сургууль, тэдгээрийн хөтөлбөрийн алба, тэнхим, багш нар хэрэгжүүлнэ.

1.3. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

- Багшийн хөгжлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх зорилт, үйл ажиллагаа нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, чиглэл болон МУБИС-ийн алсын хараа, эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөтэй уялдсан байх;
- Багшийн хөгжлийн тогтолцоог сургуулийн бодлогоор тасралтгүй, тогтвортой дэмжих;

- Дээд боловсролын байгууллагын багшийн эрдмийн эрх чөлөө, бие даасан байдлыг хангах;
- Багшийг хөгжүүлэх, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахдаа шударга, ил тод байдал, хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хангах;
- МУБИС-ийн удирдлага, бүрэлдэхүүний болон салбар сургууль, тэнхим, багш нарын хамтын ажиллагааг уялдуулан хөгжүүлэхэд чиглэсэн байх;
- Багшийн хөгжлийг хангах үйл ажиллагаа нь үе шаттай, олон улсын хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлагад нийцсэн, нээлттэй хүртээмжтэй, тасралтгүй хөгжих, мэргэжил дээшлүүлэн суралцах боломжийг бүрдүүлсэн байх;
- Багшийн ажлын үнэлгээ, албан тушаалын зэрэглэл тогтооход багшийн хөгжлийн болон багшийн ёс зүй, суралцагчдын сэтгэл ханамжийн үр дүнг харгалзан үзэх;

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

2.1. Хөтөлбөрийн зорилго

МУБИС-ийн багшийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчны зохицуулалт, сургуулийн нэгдсэн бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгож, хэрэгжилтийг сайжруулах замаар багшийн хөгжлийг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилтууд

- Зорилт 1. Багшийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчны зохицуулалт, нэгдсэн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах;
- Зорилт 2. Багшийн сургалтын арга зүйн хөгжлийг дэмжих;
- Зорилт 3. Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны онол, арга зүйн хөгжлийг дэмжих;
- Зорилт 4. Байгууллагын соёл, багшийн ёс зүйн болон хувь хүний хөгжлийг дэмжих;

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Багшийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчны зохицуулалт, нэгдсэн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах

- 3.1.1. МУБИС-ийн алсын хараа, эрхэм зорилго болон дээд боловсролын бодлого, зорилттой уялдуулан, багшийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулах замаар багшийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчныг сайжруулах;
- 3.1.2. Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны төрөл хэлбэр, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх;
- 3.1.3. МУБИС-ийн багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг цахим системээр жил бүр хичээлийн жилээр төлөвлөж хэрэгжүүлэх;

- 3.1.4. Багшийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд үнэлгээ шинжилгээ хийж, үр дүнд суурилсан сайжруулалт хийх;

3.2. Багшийн сургалтын арга зүйн хөгжлийг дэмжих

- 3.2.1. Сургалтын арга зүй технологи боловсруулах, дотоод гадаадын шилдэг арга зүй технологийг нэвтрүүлэх, үр дүнг түгээн дэлгэрүүлэхэд бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- 3.2.2. Багшийн арга зүйн хөгжлийг дэмжих сонголтот сургалт, үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах;
- 3.2.3. Багш нарыг гадаад, дотоодын урт, богино хугацааны сургалтад хамруулах;
- 3.2.4. Англи хэлээр заадаг хичээлийн тоог нэмэгдүүлэх;

3.3. Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны онол, арга зүйн хөгжлийг дэмжих

- 3.3.1. Тэнхим, хүрээлэнгийн тэргүүлэх чиглэл, тэнхим болон судалгааны багийн семинар, багш судлаачдын хамтын ажиллагаа, салбар дундын судалгааг дэмжих, үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтдийг урьж хамтарч ажиллах эрх зүйн орчныг сайжруулах;
- 3.3.2. Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг өсгөх замаар багш нарын оролцоог нэмэгдүүлж, судалгаа шинжилгээний онол, арга зүйн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, үр дүнд суурилсан цалин, шагнал урамшууллын оновчтой тогтолцоог бий болгох;
- 3.3.3. Багш, судлаачдын оюуны өмчийг баталгаажуулах, МУБИС-ийн өмчлөл, хамтран эзэмшигчээр байгаа оюуны өмчийн бүтээл болон бусад зохиогч, эрх эзэмшигч нарын бүтээлийг гэрээний үндсэн дээр эдийн засгийн эргэлтэд оруулах, цаашдын судалгаа-шинжилгээг дэмжиж үр ашгийг дээшлүүлэх, хуваарилах;
- 3.3.4. Судалгааны ёс зүйг баримтлах, академик эрх чөлөөг дээдлэх, багш, судлаачдыг мэргэжлийн хувьд өсөж дэвжихэд дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагаатай их сургууль, судалгааны байгууллагын хөтөлбөрт хамруулах боломжийг нэмэгдүүлэх;

3.4. Байгууллагын соёл, багшийн ёс зүйн болон хувь хүний хөгжлийг дэмжих

- 3.4.1. Хариуцлагатай, бүтээлч, эв нэгдэл, эрдэм мэдлэг, хүмүүнлэг чанарыг үнэт зүйлээ болгосон өөрчлөгдөн хөгжигч хамт олны төлөвшлийг дэмжих;
- 3.4.2. Багшийн харилцаа, хандлага, ёс зүйн хэм хэмжээний талаарх суралцагчдын үнэлэмжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;
- 3.4.3. Багшийн хувь хүний хөгжлийг дэмжихэд чиглэсэн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах;

дөрөв. хөтөлбөрийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги

Бодлогын баримт бичигт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2024 он/	Зорилтот түвшин /2027 он/	Санхүүгийн эх үүсвэр
Стратеги /арга зам/				
Зорилт 1. Багшийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчны зохицуулалт, нэгдсэн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах				
1. МУБИС-ийн алсын хараа, эрхэм зорилго болон дээд боловсролын бодлого, зорилттой уялдуулан, багшийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулах замаар багшийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчныг сайжруулах	Багшийн хөгжлийг дэмжих, эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн дүрэм журмын өөрчлөлт	МУБИС-ийн 21 эрх зүйн баримт бичигт багшийн хөгжлийг дэмжихтэй холбоотой заалтууд тусгагдсан. Хэрэгжилт нь 69.7%-тай байна.	Хэрэгжилтийг 90%-д хүргэнэ.	Батлагдсан төсөв, гадаад, дотоод хамтын ажиллагаатай байгууллагын тэтгэлэг
2. Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны төрөл хэлбэр, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх	Багшийн хөгжлийг дэмжих санхүүжилтийн эзлэх хувь (жил бүр)	2018-2024 онд жилд дунджаар багшийн хөгжлийг дэмжих зардлыг 8.9%-аар нэмэгдүүлсэн.	Санхүүжилтийн хэмжээг жилд тогтмол 10%-тай байгана.	Батлагдсан төсөв, эндаумент сан

3.	МУБИС-ийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг хичээлийн жилээр, цахим системд төлөвлөж хэрэгжүүлэх	Багшийн дэмжих хөгжлийг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	СУМС-д нэгдсэн төлөвлөгөөг байршуулах талбар үүсгээгүй.	СУМС-д нэгдсэн төлөвлөгөөг төлөвлөж хэрэгжүүлэх нэгдсэн мэдээллийн сантай болно.	Батлагдсан төсөв
4.	Багшийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд үнэлгээ шинжилгээ хийж, үр дүнд суурилсан сайжруулалт хийх	Багшийн хөгжлийг үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 66.1%-тай байсан.	Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 90%-д хүргэнэ.	Батлагдсан төсөв
Зорилт 2. Багшийн сургалтын арга зүйн хөгжлийг дэмжих					
1.	Сургалтын арга зүй, технологи боловсруулах, дотоод гадаадын шилдэг арга зүй технологийг нэвтрүүлэх, үр дүнг түгээн дэлгэрүүлэхэд бодлогын	Сургалтад нэвтрүүлж, түгээн дэлгэрүүлсэн арга зүй, технологийн тоо	Сургалтад үр дүнд багш суурилсан боловсролыг баримжаалсан суралцагч төвтэй сургалтын арга зүй, технологи хэрэгжиж байна.	Жилд 2-оос доошгүй арга зүй, технологи шинээр нэвтрүүлсэн байна.	Батлагдсан төсөв

4.	Англи хэлээр заадаг хичээлийн тоог нэмэгдүүлэх	Англи хэлээр заах хичээлийн тоо	Бакалаврын түвшинд 30, ахисан түвшинд 37 хичээлийг англи хэлээр зааж байна.	Англи хэлээр заах хичээлийн тоо, жилд 5-аар нэмэгдэнэ.	Батлагдсан төсөв
Зорилт 3. Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны онол, арга зүйн хөгжлийг дэмжих					
1.	Тэнхим, хүрээлэнгийн тэргүүлэх чиглэл, тэнхим болон судалгааны багийн семинар, багш судлаачдын хамтын ажиллагаа, салбар дундын судалгааг дэмжих, үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтдийг урьж хамтарч ажиллах	Тэнхим судалгааны семинарын тоо болон багийн тоо	Тэнхим болон судалгааны баг сургалт, судалгааны семинарыг зохион байгуулдаг.	Тэнхим болон судалгааны баг сургалт, семинарыг тогтмолжуулах, салбар дундын судалгааг хөгжүүлнэ.	Батлагдсан төсөв
		Урьж зочин ажиллуулсан профессор багшийн тоо	Эрдэм судалгааны чиглэлийн лекц, төсөл хөтөлбөр, хамтарч өгүүлэл бичиж хэвлүүлэх байдлаар 10 зочин профессор урьж ажиллуулсан.	Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлийн хүрээнд хамтарч ажиллах зочин профессорын тоог 15-аар нэмэгдүүлнэ.	Батлагдсан төсөв

Эрдэм судалгааны хөтөлбөрийн санхүүжилтийг өсгөх замаар багш нарын оролцоог нэмэгдүүлж, судалгаа шинжилгээний онол, арга зүйн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, үр дүнд суурилсан цалин, шагнал урамшууллын онолтой тогтолцоог бий болгох	Багшийн хөгжлийн санхүүжилтэд эзлэх хувь, (жил бүр)	Жилд дунджаар багшийн хөгжлийг дэмжих зардлын 40%-ийг зарцуулж байна.	Санхүүжилтийн хэмжээг жилд тогтмол 40%- тай байлгана.	Батлагдсан төсөв
2.	Судалгааны төсөл хөтөлбөрт оролцсон багшийн үндсэн багшид эзлэх хувь	Судалгааны төсөл хөтөлбөрт нийт багшийн 20.1% оролцсон.	Судалгааны төсөл хөтөлбөрт нийт багшийн 27.5%-ийг хамруулна.	Батлагдсан төсөв
3.	Багш, судлаачдын оюуны өмчийг баталгаажуулах, МУБИС-ийн өмчлөл, хамтран эзэмшигчээр байгаа оюуны өмчийн бүтээл болон бусад зохиогч, эрх эзэмшигч нарын бүтээлийг гэрээний үндсэн дээр эдийн засгийн эргэлтэд оруулах, цаашдын судалгаа- шинжилгээг дэмжиж үр ашгийг дээшлүүлэх, хуваарилах	Оюуны өмчийн гэрчилгээтэй бүтээлийн тоо	Оюуны өмчийн гэрчилгээтэй бүтээлийн тоог жилд 5-аас доошгүй нэмэгдүүлнэ.	Батлагдсан төсөв
	Эдийн засгийн эргэлтэд орсон бүтээлийн тоо	3 бүтээл эдийн засгийн эргэлтэд орсон.	Эдийн засгийн эргэлтэд орсон бүтээлийн тоог жилд 1-ээр нэмэгдүүлнэ.	Батлагдсан төсөв

4.	Судалгааны ёс зүйг баримтлах, академик эрх чөлөөг дээдлэх, багш, судлаачдыг мэргэжлийн хувьд өсөж дэвжихэд дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагаатай их сургууль, судалгааны байгууллагын хөтөлбөрт хамруулах боломжийг нэмэгдүүлэх	Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь	Үндсэн багшид эзлэх докторын зэрэгтэй багшийн хувь 48.1%-тай байна.	Үндсэн багшид эзлэх докторын зэрэгтэй багшийн хувийг 51%-д хүргэнэ.	Батлагдсан төсөв
		Хамтын ажиллагаатай их сургууль, судалгааны байгууллагын хөтөлбөрт хамрагдсан багшийн тоо	Хамтын ажиллагаатай их сургууль, судалгааны байгууллагын хөтөлбөрт багш нар хамрагддаг.	Хамтын ажиллагаатай их сургууль, судалгааны байгууллагын хөтөлбөрт хамрагдах багшийн тоог нэмэгдүүлнэ.	Батлагдсан төсөв
	Зорилт 4. Байгууллагын соёл, багшийн ёс зүй болон хувь хүний хөгжил, манлайллыг дэмжих				
1.	Хариуцлагатай, бүтээлч, эв нэгдэл, эрдэм мэдлэг, хүмүүнлэг чанарыг үнэт зүйлээ болгосон өөрчлөгдөн хөгжигч хамт олны төлөвшилийг дэмжих	Байгууллагын соёлыг дэмжих чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	Байгууллагын соёлыг дэмжих чиглэлээр 5 үйл ажиллагаа зохион байгуулсан.	Байгууллагын соёлыг дэмжих чиглэлээр жилд 5-аас доошгүй үйл ажиллагаа зохион байгуулж тогтмолжуулна.	Батлагдсан төсөв

2.	Багшийн харилцаа, хандлага, ёс зүйн хэм хэмжээний суралцагчдын үнэлэмжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх	Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны хувь	Багшийн харилцаа, хандлага, ёс зүйн хэм хэмжээний талаарх суралцагчийн сэтгэл ханамж 82.3%-тай байна.	Багшийн харилцаа, хандлага, ёс зүйн хэм хэмжээний талаарх суралцагчийн сэтгэл ханамжийг 88%-д хүргэнэ.	Батлагдсан төсөв
3.	Багшийн хувь хүний хөгжил, манлайллыг дэмжихэд чиглэсэн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	Багшийн хувь хүний хөгжлийг дэмжсэн 4 үйл ажиллагаа зохион байгуулсан.	Багшийн хувь хүний хөгжлийг дэмжих үйл ажиллагааг жилд 2-оос доошгүй нэмэгдүүлж, тогтмолжуулна.	Батлагдсан төсөв
		Багшийн хөгжлийн санхүүжилтэд хувь хүний хөгжлийг дэмжсэн зардлын эзлэх хувь, (жил бүр)	Жилд дунджаар багшийн хөгжлийг дэмжих зардлын 20%-ийг зарцуулж байна.	Санхүүжилтийн хэмжээг жилд тогтмол 20%-тай байлгана.	Батлагдсан төсөв

ТАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МУБИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр /2024-2027/-ийн ахиц дэвшлийг дараах гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтээр хэмжих бөгөөд жил бүрийн гүйцэтгэлийг дараах байдлаар тодорхойлж байна.

№	Үзүүлэлт (KPI)	2024 /Суурь түвшин /	Түлхүүр	2025	2026	2027
1.	Багшийн хөгжлийг дэмжих санхүүжилтийн эзлэх хувь (жил бүр)	8.9%	Багшийн хөгжлийг дэмжих төрөл бүрийн тэтгэлэг, сургалт судалгаанд зарцуулах санхүүжилтийн хэмжээг өсөлтийн хувиар илэрхийлнэ.	10%	10%	10%
2.	Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	66.1%	Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	80%	84%	90%
3.	Сургалтад нэвтрүүлж, түгээн дэлгэрүүлсэн арга зүй, технологийн тоо (жил бүр)	-	Сургалтад нэвтрүүлж, түгээн дэлгэрүүлсэн арга зүй, технологийн тоо	2-оос доошгүй	2-оос доошгүй	2-оос доошгүй
4.	Сургалтын арга зүй, технологи нэвтрүүлэх, үр дүнг түгээн дэлгэрүүлэхэд зарцуулсан төсвийн эзлэх хувь	40%	Багшийн хөгжлийг дэмжих санхүүжилтээс сургалтын арга зүй, технологи нэвтрүүлэх, үр дүнг түгээн дэлгэрүүлэхэд зарцуулсан хувь	40%	40%	40%
5.	Сонголтот сургалт, үйл ажиллагаанд хамрагдсан багшийн эзлэх хувь	70%	Сонголтот сургалт, үйл ажиллагаанд хамрагдсан багшийн тоог нийт багшийн тоонд харьцуулан хувиар илэрхийлнэ.	90%	92%	95%

6.	Гадаад, дотоодын сургалтад хамрагдсан багшийн эзлэх хувь	83%	Тухайн жилд үндсэн багшид гадаад дотоодод мэргэжил дээшлүүлсэн, сургалтанд хамрагдсан багшийн эзлэх хувь	85%	88% 90%
7.	Англи хэлээр заах хичээлийн тоо	67	Англи хэлээрх хичээлийн тоо	5-аас доошгүй	5-аас доошгүй
8.	Урьж ажиллуулсан зочин профессор багшийн тоо	10	Урьж ажиллуулсан зочин профессор багшийн тоо	12	15
9.	Багшийн хөгжлийн санхүүжилтэд эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хөтөлбөрийн төсвийн эзлэх хувь, (жил бүр)	40%	Нийт төсөвт эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хөтөлбөрүүдэд зарцуулсан зардлын эзлэх хувиар илэрхийлнэ.	40%	40%
10.	Судалгааны төсөл хөтөлбөрт оролцсон багшийн үндсэн багшид эзлэх хувь	20.1%	Дотоодын болон олон улсын судалгааны санхүүжилт авч төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй багшийн тоог үндсэн багшийн тоонд харьцуулж хувиар илэрхийлнэ.	22.5%	27.5%
11.	Оюуны өмчийн гэрчилгээтэй бүтээлийн тоо (жил бүр)	9	Гэрчилгээгээр баталгаажсан, мөн сургууль дээр хөгжүүлэлт, бойжуулалт хийсэн сургуулийн (цахим хичээлийн хэрэглэгдэхүүн, интерактив хичээл гэх мэт).	5≤	5≤

12.	Эдийн засгийн эргэлтэд орсон бүтээлийн тоо	3	Багш судлаачдын оюуны өмчийн бүтээл болон бусад зохиогч, эрх эзэмшигчдийн бүтээл	1≤	1≤	1≤
13.	Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь	48.1%	Эрдмийн зэрэгтэй багшийн тоог үндсэн багшийн тоонд харьцуулна.	49.1%	49.8%	51%
14.	Байгууллагын соёлыг дэмжих чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	5	Байгууллагын соёл, эв нэгдэл, хүмүүнлэг чанарыг үнэт зүйлээ болгосон бүхий л үйл ажиллагааны тоо	5≤	5≤	5≤
15.	Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны хувь	82.3%	Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүн	84%	86%	88%
16.	Багшийн хувь хүний хөгжил, манлайллыг дэмжих чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тоо (жил бүр)	4	Багшийн хэл, соёл, сэтгэл зүйн болон бусад дэмжлэг бүхий үйл ажиллагааны тоо	2-оос доошгүй	2-оос доошгүй	2-оос доошгүй
17.	Багшийн хөгжлийн санхүүжилтэд хувь хүний хөгжлийг дэмжсэн зардлын эзлэх хувь, (жил бүр)	20%	Нийт төсөвт багшийн хувь хүний хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааны зардлын эзлэх хувиар илэрхийлнэ.	20%	20%	20%

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 6.1. "Багшийн хөгжлийн хөтөлбөр"-ийн зорилго, шалгуур үзүүлэлтийг хангахад чиглэсэн багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөг хичээлийн жилийн хаврын улиралд МУБИС-ийн хэмжээнд болон бүрэлдэхүүн, салбар сургууль, тэнхим, багш бүр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 6.2. "Багшийн хөгжлийн хөтөлбөр"-ийг удирдлага, төлөвлөлтөөр хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах үүргийг Сургалт, цахим шилжилтийн хэлтэс, шинжилгээ үнэлгээ хийх үүргийг Чанарын баталгаажуулалт, мониторингийн алба хүлээнэ.
- 6.3. "Багшийн хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Сургалт, цахим шилжилтийн хэлтэс, бүрэлдэхүүний болон салбар сургууль, тэнхимтэй хамтран зохион байгуулж ажиллана.
- 6.4. Ажлын байран дээр нь багшийг хөгжүүлэх бүхий л ажлыг бүрэлдэхүүний болон салбар сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч нар зохион байгуулж хэрэгжүүлнэ.
- 6.5. Багш нарыг хөгжүүлэх, мэргэжил дээшлүүлэхэд шаардлагатай мэдээлэл, арга зүйгээр хангах, нэгдсэн сургалт-семинар зохион байгуулах үйл ажиллагааг Сургалт, цахим шилжилтийн хэлтэс болон бусад холбогдох алба нэгжүүд хариуцаж ажиллана.
- 6.6. Багшийг хөгжүүлэх, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, сургалт явуулах сургагч багш нарыг бэлтгэх, дэмжих, чадавхжуулахад чиглэсэн орчин нөхцөлийг бүрдүүлэх ажлыг Сургалт, цахим шилжилтийн хэлтэс, бүрэлдэхүүний болон салбар сургуулиуд хариуцна.
- 6.7. "Багшийн хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх бодлого, зорилт, холбогдох дүрэм журам, шаардлагатай төсөв, хөрөнгө оруулалтыг Ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцэж батална.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ


- 7.1 Хөтөлбөрийн хэрэгжилтэд шинжилгээ, үнэлгээ хийх зорилго нь МУБИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг сайжруулахад оршино.
- 7.2. Багшийн хөгжлийн хөтөлбөрийн зорилтын хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагааны гүйцэтгэлийг багш жил бүр 05 дугаар сарын 15-ны дотор тэнхимдээ хүргүүлэх бөгөөд тэнхимийн хурлаар тайланг хэлэлцэн дүгнэж, 05 дугаар сарын 20-ны дотор бүрэлдэхүүний болон салбар сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

7.3. Бүрэлдэхүүний болон салбар сургууль тухайн хичээлийн жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэн, жил бүрийн 5 дугаар сарын 25-ны дотор Чанарын баталгаажуулалт, мониторингийн албанд ирүүлнэ.

7.4. Шинжилгээ, үнэлгээг Чанарын баталгаажуулалт, мониторингийн алба жил бүр Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан аргачлалын дагуу хийж, төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал, зөвлөмж боловсруулан, 6 дугаар сарын 15-ны дотор багтаан МУБИС-ийн Ректорын зөвлөлийн хуралд танилцуулна.

7.5. Бүрэлдэхүүний болон салбар сургуулийн тайлан, Чанарын баталгаажуулалт, мониторингийн албаны үнэлгээ, санал, зөвлөмжийг Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн нэгдсэн цахим мэдээллийн санд байршуулна.

7.6. Чанарын баталгаажуулалт, мониторингийн албаны үнэлгээ, санал, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн зорилт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль дүрэм, журамд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулж болно.



НАЙМ. САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийг дараах дараах эх үүсвэрүүдээс санхүүжүүлнэ. Үүнд:

- МУБИС-ийн төвлөрсөн ба бүрэлдэхүүн, салбар сургуулиудын төсөв
- Улсын төвлөрсөн төсөв болон олон улсын байгууллага, хандивлагч орны буцалтгүй тусламж
- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн хандив, хөрөнгө
- Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр зэрэг болно.

